Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн
байнгын хорооны 2020 оны .... дугаар
тогтоолын хоёрдугаар хавсралт

## НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН АНКЕТ

| Д/д | Шалгуур үзүүлэлт | Мэдээлэл |
|---|---|---|
| 1 | **Нэр**<br>Овог, эцэг, эхийн нэр, өөрийн нэр, нэрээ өөрчилж байсан бол өмнө нь хэрэглэж байсан нэр | Чингүүнжав. Санжмятавын Энхбаяр |
| 2 | **Хүсэлт гаргагчийн хаяг**<br>Иргэний үнэмлэхэд байгаа хаяг | |
| 3 | **Төрсөн огноо**<br>Төрсөн газар | |
| 4 | **Боловсрол**<br>Дээд боловсрол эзэмшсэн сургууль тус бүрийг сүүлд төгссөн сургуулиас нь эхлэн жагсаан бичнэ. Сургууль тус бүрд суралцсан хугацаа, авсан зэрэг, огноог бичнэ. | 1. Удирдлагын академи, Удирдахуйн ухааны сургууль, Төрийн захиргааны менежментын магистер. 2018.12-2020.05 сар.<br>2. Удирдлагын академи, удирдахуйн ухааны сургууль, Бизнесийн удирдлагын мэргэшлийн диплом. 2016.12-2018.04 сар.<br>3. Украйн Улсын их сургуулийн Олон улсын харилцааны дээд сургуулийн Олон улсын нийтийн эрх зүйч. 1995.09-2000.07 сар. |
| 5 | **Ажил эрхлэлт**<br>Их, дээд сургууль төгссөнөөс хойш ажилласан төрийн байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага болон бусад байгууллагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсаан бичнэ. Ажил олгогчийн нэр, хаяг, утас, цахим хуудас болон ажлын байрны нэрийг бичнэ. | 1. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар. Чингисийн өргөн чөлөө, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, УБ хот-17032 (www.emdeg.gov.mn), 7010 0005.<br>2. Шүүхийн ерөнхий зөвлөл. Тасганы овоо, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Зип-15170, (www.judcouncil.mn), 70008045.<br>3. Санхүүгийн зохицуулах хороо, Бага тойруу, Чингэлтэй дүүрэг. 264444.<br>4. Улсын Их Хурлын Тамгын газар. 14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Жанжин Д.Сүхбаатарын талбай, Төрийн ордон, 267016. |
| 6 | **Нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаал**<br>Хүний эрхийн Үндэсний | Хүний эрхийн Үндэсний комиссын гишүүнд |

| | | |
|---|---|---|
| | Комиссын гишүүн эсхүл Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний алинд нэр дэвшиж байгаа талаар бичнэ. | |
| 7 | **Эрх зүйч мэргэжлээр эрхэлсэн ажил**<br>Хүсэлт гаргагч эрх зүйч мэргэжлээр сүүлийн арваас доошгүй жил эрхэлсэн ажлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дараалаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ.<br>-албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа;<br>-ажлын байрны тодорхойлолт;<br>-удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл;<br>-хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл. | 1.Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Тамгын газрын дарга. Чингисийн өргөн чөлөө, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, УБ хот-17032. 2019.03-2020.04 сар.<br>• Эрүүл мэндийн даатгалын даатгуулагч иргэдийн эрх ашгийг хамгаалах, зөрчлийн талаарх иргэдийн гомдол, мэдээллийн дагуу хянан шалгах, захиргаа, хүний нөөц, эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний гэрээ, хууль зүйн үйлчилгээ,<br>•<br>2.Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн захиргааны удирдлагын газрын дарга, ахлах референт, Шүүхийн хүний нөөцийн газрын дарга. Тасганы овоо, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо. 2012.06-2019.01 сар.<br>• Шүүхийн захиргааны байгууллагууд буюу Шүүхийн тамгын газруудыг захиргаа, хүний нөөц, зохион байгуулалт, хууль, эрх зүйн туслалцаа болон мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах.<br>3.Санхүүгийн зохицуулах хорооны даргын хуулийн зөвлөх. Бага тойруу, Чингэлтэй дүүрэг. 2006.06-2009.01сар.<br>• Байгууллагын хууль, эрх зүйн тусламж үйлчилгээ, байгууллагыг хууль хууль хяналт, шүүхийн байгууллагад төлөөлөх, эрх баримт бичиг, хууль тогтоомж, дүрэм, журмын төсөл боловсруулах.<br>4.Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн хэлтэс, Хууль зүйн байнгын хорооны Ажлын албаны зохион байгуулагч, референт, зөвлөх, Хуулийн хэлтсийн хуулийн зөвлөх. Сүхбаатар дүүрэг, Жанжин Д.Сүхбаатарын талбай, Төрийн ордон. 2001.05-2006.06, 2019.01-2012.06.<br>• Эрх зүйн бодлого, хүний эрх, эрх чөлөө, хууль зүйн хариуцлага хүлээлгэх эрх зүйн үндэс, ялын бодлого, хууль хяналтын байгууллагын эрх зүйн бодлого, түүний хэрэгжилтэд хяналт тавихад мэргэжил арга зүй, техник зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх. |
| 8 | **Ёс зүй**<br>Доор дурсан асуудлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дараалаар бичиж, түүний гол агуулгыг тодорхойлно.<br>-сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж байсан эсэх;<br>-сүүлийн таван жилд улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан | 1.Сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж, чөлөөлөгдөж байгаагүй.<br>2.Улс төрийн албан тушаал эрхэлж байгаагүй. |

| | | |
|---|---|---|
| | тушаал эрхэлж байсан эсэх. | |
| 9 | **Хууль зүйн өндөр мэдлэг, чадвар**<br>Хүсэлт гарагчийг хууль зүйн өндөр мэдлэг, чадвартай гэдгийг нотлон харуулах хамгийн чухал 10 мэргэжлийн үйл ажиллагааг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дараалалаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ.<br>-үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа;<br>-үйл ажиллагааны гол агуулга;<br>-үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ;<br>-үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл;<br>-хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл;<br>-хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар. | 1. Хууль зүйн байнгын хороонд ажиллаж байх хугацаандаа Хүний эрхийн Үндэсний комиссын жил бүрийн хүний эрхийн талаарх илтгэлд дүн шинжилгээ хийж, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолын төсөл боловсруулсан. Мөн 100 гаран хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хуулийн зөвлөхийн хувьд эх барьж ажиллаж, батлуулжээ.<br><br>2.Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн оролцоонд хийсэн дүн шинжилгээ сэдвээр магистерийн дипломын ажлыг сонгож хамгаалсан.<br><br>3. Шүүхийн ерөнхий зөвлөлд байхад Шүүхийн байрны нэгдсэн стандартын болон шүүхийн үйлчилгээний төслийг боловсруулж, Шүүхийн ерөнхий зөвлөлийн хуралдаанд оруулж батлуулсан. Энэ шийдвэрийн төсөл нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн, өндөр настан, насанд хүрээгүй хүүхдэд шүүхийн үйлчилгээг үзүүлэхдээ хэрхэн оролцох, аюулгүй байдлыг хэрхэн хангах, ямар өрөөнд түр байрлуулах, хараагүй болон хараа муутай иргэнд хэрхэн үйлчлэх, шүүх танхимд нүдний шил байрлуулах, шүүх хурлыг дуу болон дүрс бичлэгээр баримтжуулж байх, хорих ангиас сэжигтэн, яллагдагч заавал оролцох боломжийг бүрдүүлэх зорилгоор цахимаар зайнаас оролцуулж байх зэрэг хүний эрхийг хангасан эрх зүйн баримт бичгийг боловсруулж, өнөөдөр хэрэгжиж байна.<br><br>4. Шүүхийн ерөнхий зөвлөл ажиллаж байхдаа Шүүхийн тухай багц хуулиуд болох 6 хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллахдаа зохион байгуулалтын ажлаас гадна багу хуулиудаар эрхийг нь олгосон 44 дүрэм, журмын төслийг боловсруулахдаа хүний эрх, эрх чөлөө, иргэний хяналтыг хэрхэн үр нөлөөтэй байхад анхаарлаа хандуулан ажилласан.<br><br>5. Хууль зүйн байнгын хороонд ажиллаж байх хугацаандаа Хүний эрхийн үндэсний комисс, Цагдаагийн байгууллага, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, хорих ангиудын үйл ажиллагаа, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шалгалтын Байнгын хорооны ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллаж байсан.<br><br>6. Хорих ангиуд дотоодын хууль тогтоомж, олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг, стандартыг хэрхэн хангаж буй талаар хяналт шалгалт хийх үүрэг бүхий Байнгын хорооны ажлын хэсгийн бүртэлдэхүүнд орж, шалгалтын дүнгийн тайлан, болон тогтоолын төслийг боловсруулж, Байнгын хороо, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан.<br><br>7. 2002 онд батлагдсан Шүүхийн тухай, Эрүү, Иргэний хууль, тэдгээрийн процессийн хуулиудыг боловсруулах, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхэд мэргэжил, арга зүй, |

| | | |
|---|---|---|
| | | судалгааны туслалцаа үзүүлж байсан.<br><br>8.Шүүхийн ерөнхий зөвлөлд ажиллаж байхдаа шүүхийн хэргийн хөдөлгөөний цахим системийг хийх техникийн даалгаврыг боловсруулахад хариуцсан газрын даргын хувьд оролцож байсан. Энэ систем нь 2014 онд нэвтэрсэн бөгөөд шүүх, шүүгч, шүүхийн захиргааны ажилтан хэрэг, маргаан, нэхэмжлэхийг хүлээж авсан цагаас эхлэн шийдвэрлэх хүртэл хугацаанд хэрхэн ажиллахыг цаг хугацаа, ажиллагааны дарааллыг нарийн зохицуулж өгсөнөөр хэргийн зохигч, сэжигтэн, яллагдагч нарын эрхийг хангахад чухал шийдэл болсон.<br>9.2016 онд батлагдсан Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу Санхүүгийн зохицуулах хороо шинээр байгуулагдаж, хуульчийн хувьд олон шинэ байгууллагын олон дүрэм, журмыг боловсруулж эрх бүхий байгууллагаар батлуулсан байна.<br><br>10. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Тамгын газрын даргаар томилогдсон даруйдаа иргэд, даатгуулагчдын төлсөн шимтгэл болох Эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг боловсронгуй болгож, цахим бүртгэл, төлбөр, хяналтын системийг нэвтрүүлж, даатгуулагч иргэн өөрийн мөнгийг хянах, зөвхөн хурууны хээг уншуулах замаар төлбөр төлөгддөг болгосон. Мөн даатгуулагчдын нэр, регистерийн дугаараар хуурамч баримт бүрдүүлэн сангаас олон тэрбум төгрөг нэхэмжилж авдаг байсан зарим лабораторын үйл ажиллагаанд хяналт шалгалт оруулж, олон тооны зөрчил илрүүлж, улмаар олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шинжилгээний тоног төхөөрөмжтэй болгуулж, шинжилгээний чанарт үр нөлөөгөө өгч, зарим байгууллагыг торгосон. Тухайлбал, “Хаппи веритас лаборатор” ХХК-ийг 790.0 сая төгрөгийн торгууль ногдуулж, шүүхэд ялалт байгуулсан.<br><br>Мөн Эрүүл мэндийн даатгалын сангийн 136.1 тэрбум төгрөгийг хадгалж байсан Капитал банк дампуурсантай холбогдуулан иргэдийн эрүүл мэндийг эрсдэлээс хамгаалах, сангийг хөрөнгийг бүрэн эргүүлэн авах зорилгоор төлбөр барагдуулах дарааллын хамгийн сүүлд жагсаж байсаныг урагшлуулж авахаар шүүхэд хандаж ялалт байгуулсан.<br><br>11.Санхүүгийн зохицуулах хороо анх байгуулагдсан даруйдаа Хадгаламж зээлийн хоршоодын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, олон арван мянган хадгаламж эзэмшигч иргэдийг хохироож байсаныг илрүүлж, хохирлыг барагдуулах, эрх зүйн хувьд цаашид хэрхэн боловсронгуй болгоход багагүй хугацааг Хорооны зөвлөхийн хувьд, Хууль зүйн байнгын хорооны ажлын хэсгийн бүрэлдэхүүнд байхдаа зарцуулжээ.<br><br>12. Хууль, УИХ-ын бусад шийдвэрийн талаар олон нийтэд мэдээлэх, санал бодлыг авах, нээлттэй хэлэлцүүлэг, бага хурал, сонсголыг Байнгын хороод ажиллаж байхдаа олон удаа зохион байгуулсан. Тухайлбал, “Хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх” сэдэвт УИХ-ын нээлттэй сонсгол, Хууль зүйн байнгын хороо болон Хүний эрхийн дэд хороо хамтран “2008 оны 7 дугаар сарын 1 ба хүний эрх” сэдэвт нээлттэй сонсголыг зохион байгуулж, гарсан санал дүгнэлт, зөвлөмжийг боловсруулсан. |
| **10** | **Хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах чиглэлээр эрхэлсэн ажил** | 1.Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Тамгын газрын дарга. Чингисийн өргөн чөлөө, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, УБ хот-17032. 2019.03-2020.04 сар. |

| | | |
|---|---|---|
| | Хүсэлт гарагч хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах чиглэлээр сүүлийн тавaас доошгүй жил эрхэлсэн ажлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дараалаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ:<br>-албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа;<br>-ажлын байрны тодорхойлолт;<br>-удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл;<br>-хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл. | • Эрүүл мэндийн даатгалын даатгуулагч иргэдийн эрх ашгийг хамгаалах, зөрчлийн талаарх иргэдийн гомдол, мэдээллийн дагуу хянан шалгах, захиргаа, хүний нөөц, эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний гэрээ, хууль зүйн үйлчилгээ.<br>•<br>2.Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн захиргааны удирдлагын газрын дарга, ахлах референт, Шүүхийн хүний нөөцийн газрын дарга. Тасганы овоо, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо. 2012.06-2019.01 сар.<br>• Шүүхийн захиргааны байгууллагууд буюу Шүүхийн тамгын газруудыг захиргаа, хүний нөөц, зохион байгуулалт, хууль, эрх зүйн туслалцаа болон мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах.<br>3.Санхүүгийн зохицуулах хорооны даргын хуулийн зөвлөх. Бага тойруу, Чингэлтэй дүүрэг. 2006.06-2009.01сар.<br>• Байгууллагын хууль, эрх зүйн тусламж үйлчилгээ, байгууллагыг хууль хууль хяналт, шүүхийн байгууллагад төлөөлөх, эрх баримт бичиг, хууль тогтоомж, дүрэм, журмын төсөл боловсруулах. 4.Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн хэлтэс, Хууль зүйн байнгын хорооны Ажлын албаны зохион байгуулагч, референт, зөвлөх, Хуулийн хэлтсийн хуулийн зөвлөх. Сүхбаатар дүүрэг, Жанжин Д.Сүхбаатарын талбай, Төрийн ордон. 2001.05-2006.06, 2019.01-2012.06.<br>• Эрх зүйн бодлого, хүний эрх, эрх чөлөө, хууль зүйн хариуцлага хүлээлгэх эрх зүйн үндэс, ялын бодлого, хууль хяналтын байгууллагын эрх зүйн бодлого, түүний хэрэгжилтэд хяналт тавихад мэргэжил арга зүй, техник зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх. |
| **12** | **Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны туршлагын талаар**<br>Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний албан тушаалд нэр дэвших тухай хүсэлт гаргагч нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мөрдөгч, өмгөөлөгч, прокурор, шүүгчээр ажиллаж байсан бол тэдгээрийн сүүлийнхээс нь эхлэн он дараалаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ:<br>-албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа;<br>-ажлын байрны тодорхойлолт; | |

| | | |
|---|---|---|
| | -удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл;<br>-хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл<br>**Жич: Энэ зүйл нь Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнд нэр дэвших тухай хүсэлт гаргагчид хамаарахгүй.** | |
| 13 | **Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар**<br>Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, хууль зүйн эсхүл хүний эрхийн бусад холбоо, байгууллагад гишүүн бол нэрлэн бичнэ.<br>-Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүн болсон огноог бичнэ. Уг байгууллагын гишүүнчлэлийг түдгэлзүүлж, хүчингүй болгож, дуусгавар болгож байсан бол энэ талаар бичиж, шалтгааныг нь тайлбарлана.<br>-Мэргэжлийн холбоо, байгууллагад эрхэлж байсан албан тушаалын нэр, огноог бичнэ. | Гишүүнчлэл байхгүй болно. |
| 14 | **Хэвлүүлсэн бүтээл болон олон нийтэд өгсөн мэдээлэл**<br>-Өөрийн боловсруулсан, хянасан ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг, хэвлэсэн газар, огноог бичнэ. | **Нэг.Боловсруулсан ном, гарын авлага.**<br>1. “Интернетээс эрх зүйн мэдээлэл авч ашиглах аргачлал”-ыг бие дааж бичиж, хэвлүүлэн Улсын Их Хурлын Тамгын газрын хуульч, Хууль зүйн яамныхан, бусад мэргэжилтэн эрх зүйчид боловсруулах гэж буй бодлогын баримт бичигтэй холбогдуулан бусад улсын туршлага, хууль тогтоомжийг олоод, мэддэг улсын хэлрүүгээ хэрхэн хөрвүүлэн цахимаар орчуулан танилцах талаарх гарын авлага юм. Энэ гарын авлагын тусламжтайгаар олон хууль тогтоомж боловсруулахад судалгааны дэмжлэг болсон. Төрийн ордон. 2003 он. Хавсаргав.<br>2. “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх нь” иргэд, төрийн албан хаагч |

| | | |
|---|---|---|
| | -Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа х болон бусад материал байгаа бол түүнийг хэвлэсэн байгууллагын нэр, хаяг, огноо, гол агуулгыг бичнэ.<br>-лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, яриа, огноо болон газрыг зааж, энэ талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр цацагдсан бол энэ тухай бичнэ. Хэрэв таны илтгэл, ярианы хуулбарыг хийх боломжгүй бол түүнийг зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч агуулгыг бичнэ.<br>-хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлагуудын огноог зааж, боломжтой бол ярилцлагын тэмдэглэл, дүрс бичлэгээс хуулбарлан өгнө.<br><br>**Жич:** Дээр дурдсан материал тус бүр хоёр хувийг хавсаргана. | нарт зориулсан гарын авлага. 2010 онд. Хууль зүйн байнгын хороонд ажиллахдаа хэвлүүлсэн. 500 ширхэг ном хэвлүүлж хууль хяналтын байгууллагад тараагдсан.<br>3. “Үндсэн хуулийн нэр томьёо” УИХ-ын номын санд хадгалагдаж байгаа.<br>4. “Шүүхийн иргэдийн төлөөлөгч” нарт зориулсан гарын авлага.<br><br>**Хоёр. Боловсруулсан хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж**<br><br>1.ШЕЗ-ийн хуралдааны дэг, ШЕЗ-ийн ажлын албаны дүрэм, Шүүхийн Тамгын газрын үйл ажиллагааны нийтлэг журам, “Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах журам" “Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлийн дүрэм”, "Эвлэрүүлэн зуучлагчийн ёс зүйн дүрэм", "Эвлэрүүлэн зуучлагчийн ёс зүйн зөрчлийг шалгах үйл ажиллагааны журам", “Эвлэрүүлэн зуучлагчийг сонгон шалгаруулах журам”, Шүүхийн иргэдийн төлөөлөгчийг сонгон шалгаруулах, ажиллуулах журам, Тангарагын журам, маягт, Шүүхийн мэдээллийн технологийн үйл ажиллагааны нийтлэг журам, “Шүүхийн шинэ менежмент” хөтөлбөр, “Шүүгч, ажилтны нийгмийн хамгааллын хөтөлбөр”, “Шүүхийн захиргааны ажилтны ажлын байранд дагаж мөрдөх харилцаа, хандлагын нийтлэг журам”, “Шүүхийн тамгын газрын үйл ажиллагааны нийтлэг журам”, “Шүүхийн байрны нийтлэг шаардлага”, “Шүүхэд албан хэрэг хөтлөх журам”, (Шүүхийн дүрэм журмын эмхтгэл 1, 2. ШЕЗөвлөлийн хуралдаанд танилцуулах хуудаснууд архивт хадгалагдаж байгаа тул тэндээс боловсруулсан, танилцуулсан албан тушаалтныг мэдэх боломжтой).<br><br>2.Эрүүгийн хууль, Иргэний хууль, Эрүүгийн байцаан шийтгэх тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдэрлэх тухай, Шүүхийн тухай, Прокурорын байгууллагын тухай, Өмгөөллийн тухай, Нотариатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Цагдаагийн байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай, Захиргааны хэргийн шүүх байгуулах тухай, Арбитрын тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулиудыг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх явцад хариуцсан Байнгын хорооны ажилтны хувьд ажилласан байна.<br><br>3.Шүүхийн захиргааны тухай хууль, Шүүхийн шинжилгээний тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Нотариатын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, дагалдах 26 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын 2009 оны төсвийн /тодотгол/ хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2009 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын 2008 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай зэрэг олон хууль тогтоомжийг зөвлөхийн хувьд эх барин ажиллаж, батлуулж, ёсчлуулсан.<br><br>Эх орны хишиг сангийн тухай, Улсын Их Хурлын нэр бүхий гишүүдээс санаачлан өргөн мэдүүлсэн Эрдэнийн хувийн (Баянмонгол корпораци) тухай хуулийн төслүүдийг нэгтгэн Хүний хөгжил сангийн тухай хуулийн төслийг боловсруулж батлуулсан.<br>Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх Хяналтын зөвлөлийн ажиллах журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоол, “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм батлах тухай” Улсын Их Хурлын тогтоол, “Санхүүгийн зохицуулах хорооны Хөдөлмөрийн дотоод журам”, “Даатгагчийн болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааг зохистой явуулах ёс зүйн журам”, “Санхүүгийн зохицуулах хорооны ажилтны |

| | | |
|---|---|---|
| | | ёс зүйн дүрэм батлах тухай журам", "Албан хэрэг хөтлөлт, баримт бичгийн боловсруулалт, түүнийг албажуулах журам"-ыг боловсруулан батлуулах ажилд хүчин чармаалт гаргаж ажилласан.<br>Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт ажилд ороод богино хугацаанд олон дүрэм, журмыг шинэчилэн боловсруулж батлуулжээ.Тухайлбал, Хөдөлмөрийн дотоод журам, Ёс зүйн хорооны дүрэм, Ажилтны ёс зүйн дүрэм, Улсын байцаагчийн ёс зүйн дүрэм, Хяналт шалгалтын нийлэг заавар, журам, Шагналын журам,<br><br>**Гурав. Лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, яриа**<br><br>Төрийн хариуцлагатай албан тушаал хашиж байхдаа харьяа байгууллагын ажилтан, албан хаагч нарт батлагдсан хууль тогтоомж, түүний хэрэгжилтийг хэрхэн хангах, удирдлага зохион байгуулалтын асуудлаар олон тооны хурал, сургалт, зөвлөгөөн, цаглаан дээр шүүгч, шүүхийн захиргааны ажилтан, тахарын алба хаагч, иргэдэд илтгэл, мэдээлэл, нээлтийн үг хэлж байсан. Тухайлбал, Шүүх, шүүгчийн аюулгүй байдлаар Тахарын нийт албан хаагч нарт зориулсан хуулийг хэрхэн хэрэгжүүлэх талаар олон өдөр сургалт хийсэн.<br>Мөн 2015 оны 01 дүгээр сард Япон Улсын Айчи мужийн Өмгөөлөгчдийн холбооны зөвлөгөөнд Монгол Улсад эвлэрүүлэн зуучлалын хууль хэрхэн хэрэгжиж үр дүнд хүрсэн талаар илтгэл тавьсан. Зураг 1.<br>**Дөрөв. Хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлагыг**<br><br>1. С.Энхбаяр: Гурван лабораторид 1.65 тэрбум төгрөгийн акт тавьсан тухай хэвлэлийн бага хурал зарлаж мэдээлэл хийсэн. 2020.01.23**.** Мэдээг хавсаргав.<br><br>2. Шинэ хуулийн талаар болон Тахарын албаны алба хаагчдад зориулсан сургалт зохин байгуулсан тухай хэвлэлийн бага хурал хийсэн, Мэдээг хавсаргав. http://court.tosontsengel.za.gov.mn/main/64--.html, 2015.03.30**.**<br><br>3. С.Энхбаяр: "Иргэдийн төлөөлөгч шүүх бүрэлдэхүүнд оролцож, шийдвэр гаргах эрхтэй болсон" асуудлаар хэвлэлүүдэд ярилцлага өгөв. 2013 он. http://www.assa.mn/a/18003, Ярилцлагыг хавсаргав.<br><br>4. Шүүхийн тухай багц хууль батлагдсантай холбогдуулан олон тооны телевизийн болон хэвлэлийн яриа, ярилцлага өгч байсан болно. |

--- oOo ---